



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2007 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 158

Улаанбаатар-2007

Гадаадад суралцуулах тухай

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2005 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 52 дугаар тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах журам", Өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт Сургалтын төрийн сангийн зээлээр өөрийн захиалгаар хүн суралцуулах эрх бүхий байгууллагуудын саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сосорбарам овогтой Энхбаярыг Гадаад хэргийн яамны захиалгаар АНУ-ын Сан-Францискогийн их сургуулийн магистрантурт ази, номхон далайн бүс нутгийн судлалын чиглэлээр, Тунсаг овогтой Тэлмэнг Монголбанкны захиалгаар АНУ-ын Миссури улсын их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр, Цэнгэмаа овогтой Уянгыг Мэдээлэл, харилцаа, холбоо, технологийн газрын захиалгаар АНУ-ын Хойд Вирджинийн их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр тус тус 2007-2008 оны хичээлийн жилээс 2 жилийн хугацаагаар Сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулсугай.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Санхүү, эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /Р.Бат-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.

САЙД

Ө.ЭНХТҮВШИН